

**ХӨХ НУУР, СҮБЭЙ, ХАЛХ АРДЫН ДУУНЫ
НӨЛӨӨ, ТУСГАЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО**

Л. Дангаажав*

Хөхнуур Сүбэйн Монголчуудын ардын дуу нь өөрийн уламжлал, өөрийн хөгжлийн онцлогтойгоор барахгүй, бас бусад газрын монгол ардын дууны нөлөө тусгалыг авсан буюу тэдэнд нөлөө тусгал үзүүлсэн байна. Нөлөө тусгал хийгээд харилцаа холбооны асуудал бол заавал нэг нь нөгөөгөө нөлөөлөх гэсэн биш, харин харилцан нөлөөлөх суурин дээр хөгждөг соёлын өвөрмөц үзэгдэл юм. Газар нутаг, орчин байдлын нөхцлөөс болоод Хөхнуур, Дээд Монголчуудын дуу нь Шинжаан болон Алшаагийн дуунд, адил бус хөгжлөөрөө харилцан нөлөөлж иржээ. Уг язгуур гарлын хувьд бүгд Ойрд дуу боловч, хөгжлийхөө явцад сонин зам мөрийг туулжээ. Жишээлбэл: Алшаад зохиогдсон зарим дуу нь Хөхнуурт уламжлах буюу Шинжаан нутагт уламжлах гэх мэт. Ялангуяа бурхны шашин Монгол нутагт уламжлахын дагуу шарын шашны сүм хийд буюу лам хувилгаадтай холбоо бүхий дууны тархах нөлөө зэрэг нь түгээмэл байсан тул Ойрд дуу хийгээд халх ардын дуу, ардын соёл, түүх, заншил зэрэг нь нягт харьцаатай болжээ. Иймээс Хөхнуур Сүбэй Монголчуудын ардын дуу хийгээд Халх ардын дууны харьцаа холбооны асуудлыг ярих нь чухамдаа Ойрд дуу хийгээд Халх дууны харьцаа холбооны асуудлын нэг хэсэг юм. Ялангуяа Хөхнуур Сүбэй Монголчуудын ардын дууны хөгжил мандал, уламжлалын онцлогийг илэрхийлэхийн нэгэн чухал тал байгаа юм. Хөхнуур Сүбэй Монголчуудын дуу хийгээд Халхын дууны харьцаа ямар вэ гэвэл энэ талаар бид *“Хөхнуур Сүбэй Монголчууд ба Ар Богд Жавзандамба хутагтын дуу”*, *“Ойрд монгол ардын дууны хурим найрын шинэс онцлог”* гэх өгүүлэлд тусгай авч үзсэн боловч зөвхөн эдгээр дуунуудад биш бас олон янзын дууны жишээг авч ярьж болох талтай юм. Өмнөх өгүүлэлд, өөр орон нутагт биш зөвхөн Хөхнуур, Ганьсугийн Монголчуудын дунд дуулагдаж байгаа дуунд, Ар богд Жавзандамба хутагтыг Төвдөөс залж авчирсан тухай, Хөхнуурын Монголчууд хэрхэн сүсэглэж угтаж байгаа, тэрчлэн Ордос, Ар халх хийгээд Бээжин, Лхас зууд Жавзандамба хутагтын нөлөө тусгал хэрхэн, ямар байсан гэдгийг тусгасан сонин мөр бадгийн тухай тодруулан өгүүлсэн билээ. Нөгөө нэг өгүүлэлд бол, бүх Монголд нийтээрээ дуулж байгаа *“Хөхөө шувуу”* гэх хуримын дууны харьцуулал судалгаагаар дамжин Хөхнуур Сүбэй Монголчуудын дунд уламжилж байгаа *“Хөхөө шувуу”* дууны өвөрмөц онцлогийг тодорхойлсон юм. Хөхнуур Сүбэй Монголчуудын дунд дуулагдаж байгаа ар халхын дууны уламжлал бол ерөнхийдөө доорх хоёр замаар уламжилжээ. Нэг нь эрт үеэс Халхын хүмүүс Баруун зууд явж, зам зуур удаан хугацаагаар саатан сууж, Хөхнуур, Сүбэй монголчуудтай ойр дотно болдог байсан болон ялангуяа 17-р дугаар

* Баруун Хойтын Үндэстний Их Сургууль, БНХАУ

зууны үед Халхын Цогт тайжийн дагуулсан нэг бүлэг халхчууд Хөхнуурт орж ирж, Хөхнуурын Хай Яан, Хай Бэйн зэрэг газрыг эзлэн сууж байжээ. Эдүгээ ч гэсэн Цогт тайжийн дагуулж ирэгсдийн хойчис Хөхнуурт бий. Хэдийбээр зарим нь Төвд болсон боловч ардын аман зохиол, ардын дуунууд нь Хөхнуурын Монголчуудын дунд уламжилж үлдсэн байна. Нөгөө нэг уламжлах болсон шалтгаан нь 20-р зууны 20, 30-аад оны үеэр Ар Халхаас цагаачилж ирсэн Халхчуудаас уламжилсан ардын дуу, аман зохиол, үлгэр, домог зэрэг нь Хөхнуур Сүбэй Монголчуудын дунд нэлээд бий. Иймээс одоогийн хэвлэгдэн гарч байгаа ном сударт угтаа Хөхнуур Сүбэйн аль нэг газарт байсан халх хүнээс сонсож авсан юм гэдгийг тэмдэглэсэн жишээ нэлээд бий. Чойдандар профессорын *“Баруун цастын Халх угсаатны судлал”*¹ номд орсон зарим үлгэрийг Сүбэйд байсан нэг халх хүн ярьсан гэж тодорхой тэмдэглэж байсан буюу Халиун, Оюунцэцэг нарын *“Дээд монголын газрын нэрийн домог”* ном дахь *“Эвийн хөвөөн дэх Далантай өвгөн”*² гэх үлгэр нь Алшаа дахь халхчуудын дунд яригддаг *“Далантай өвгөн”*³ гэх үлгэртэй их төстэй байдаг. Н.Цэрэнбал, Гүнрэгмаа нарын цуглуулан эмхэтгэсэн *“Дээд монголын ардын дуу”* номд *“Цагаан тохой нутаг”*, *“Шовгор Даржаа”* *“Даржаа гуай”* гэсэн дууг тэмдэглэжээ. Мөн дууг Ар халхын хүн зохиосон тухай үлгэр, намтартай тайлбар хийсэн байна⁴. Мөн 1980 оны үеэс Сүбэйн Монголчуудын дунд *(Сүрээ Настан гэх мэт)* халхын хүний дуулсан нэлээд дууг Баруун Хойдын Үндэстний Их Суруулийн оюутнууд тэмдэглэж үлдээсэн байна⁵. Мөн Хөхнуурын аман зохиол цуглуулагч, аман түүхч Х. Чүлтэм гуайн яриагаар түүнийг бага байхад, нутагт нь хоёр халх настан байжээ. Ингэнд ботго авахуулах гэж өнчин цагаан ботго хэмээх дууг маш сайхан аясаар дуулж байсан тухай дурсан ярьсан байдаг. Хөхнуурын аман үлгэрт Халх аман үлгэрийн уламжлал нэлээд бий. Хөхнуур, Сүбэйн монголчуудын дунд дуулагдаж байх мөртлөө Ар халхад уламжилсан, эсхүл ар халхын дуу нь Хөхнуур, Сүбэйн монголчуудын дунд уламжилсан гэх хоёр талаар бид Хөхнуур Монголчуудын ардын дуу хийгээд халх ардын дууны харилцааг өгүүлье. Нэгдүгээрт *“Хүжийн утаа”*, *“Сэра, Барайбүн, Галдан хийд”*, *“Газрын холоос гүйдэлтэй алтан шарга морь”*, *“Нарийн шаргал морь”*, *“Солонгын өнгөт улаан”*, *“Хөхөө шувуу”* зэрэг нэлээд дуу бий. Эдгээр дууг уламжлах болсны шалтгаан нь хоёр байна. Нэг нь шашны агуулгатай дуу. Ар богд Жавзундамбыг Төвдөөс монгол нутагт залж авчирахтай холбогдсон дуу юм. Сүм хийд, Дээд гурван Богдтой холбогдсон бурхан номын сүсэг бишрэлийн талаар халх хийгээд Хөхнуур Дээд монголчууд нэгэн адил сэтгэлтэй байдаг болохоор, дээр дурдсан *“Хүжийн утаа”* гэх мэт дууг нийтээр дуулж уламжлах болжээ. Нөгөө нэг нь хурим найрын дуу болно. Хурим найр гэдэг бол хүний амьдралаас салж болшгүй агуулга тул ерөнхийдөө тогтвортой бөгөөд урт хугацаагаар уламжилдаг шинж чанартай үзэгдэл юм. Учир нь энэ бол хүний амьдрал, хувь заяатай холбогдож байдаг

¹ Чойдандар (2007) *Баруун Цастын Халх угсаатны судлал*. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо.,

² Халиун, Оюунцэцэг (2001) *Дээд монголын газрын нэрийн домог*. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо.,

³ Бат. Д. (1999) *Цахиурт мэргэн Богд хаан. Алшаа дахь халхчуудын аман үлгэрийн түүвэр*. Улаанбаатар.,

⁴ Цэрэнбал, Гүнрэгмаа (2000) *Дээд Монголын ардын дуу*. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо.,

⁵ *Өвөрмонгол ардын дуу*. (1980) Баруун Хойтын Үндэстний Дээд Сургуулийн 1977 онд элссэн монгол салбарын оюутны цуглуулсан материал.,

учраас хэн хүн дураараа хуримын ёсыг өөрчилж үл болох зүйл билээ. Тиймээс хаа газрын ёс заншилд хуримын ёсыг ихээр хүндэтгэж, зүй ёс, дүрэм горимоор нь гүйцэтгэхийг эрхэмлэдэг. Тийм учир хурим найрын дуу ч мартагдахгүй уламжилж, газар газрын онцлог шинжээр баяжин хөгжсөөр иржээ. Хөхнуур Сүбэй Монголчуудад уламжилж байгаа “Солонгын өнгөтэй улаан”, “Хөхөө шувуу” дуу бол зөвхөн Хөхнуур Сүбэй Монголчуудын дуу биш нийт Монголчуудын дунд дуулагдаж байгаа ч, Хөхнуур Сүбэй Монголчуудын эдгээр дуунд бас өөрийн онцлог шинж байгаа нь тодорхой байна. Хөхнуур Монголчуудын дунд уламжилж байгаа Халх ардын дуунд “Хөвлөг хангайн бараа”, “Нарийн баахан шарга”, “Үрээ үрээ зээрд”, “Хэнз сайвар хээр”, “Гуугийн өндөр” гэх мэт дуу бий. Гарцаагүй зарим дууны нэр нь өөрчлөгдөж өөр болсон боловч агуулга нь адил байх буюу зарим дууны нэр нь ижил, агуулга нь ондоо болсон үзэгдэл ч зөндөө бий. Доор бид “Хөвлөг хангайн бараа ” буюу Хөхнуурт “Хивлиг хангайн бараа” гэдэг дуунаас эш татан үзье.

“Хивлиг хангайн бараа нь уужмын сэрүүгээр тунгалаг

Хөөрхий садан ах нар найрлан сууж жаргалаа

Улаан шандын усыг улаан зээрдээрээ гаталбаа

Олон элэгтэнтэйгээ догдлон сууж жаргалаа

Хөх шандын усыг хөххөн мориороо тууллаа

Хөгийн буурал аавтайгаа догдлон сууж жаргалаа”⁶ гэж дуулж байна. Энэ дууг халх монголын “Хөвлөг хангайн бараа” гэх дуутай харьцуулбал, үг, бадаг, мөр, агуулгад нэлээд өөрчлөлт гарч, засагдаж нэмэгдсэн буюу гээгдэж хоцрогдсон зүйл байдаг боловч үндсэн хөг аяс, дуу нь мөн ёсоороо байгаа гэж хэлж болох талтай. Энэ дуу уламжлахын нэг шалтгаан нь дууг зохиосон хүмүүн бол Ар халхын жонон вангийн хошууны Гэгээнтний Дүвчин дүр юм⁷. Халхын жонон вангийн хошууны Гэгээнтний Дүвчин дүрийг, Дугарзайсаны хувилгаан дүр гэдэг. Гэтэл Хөхнуурт Дугарзайсаныг Зүүнгарын ноён Цэвээнравданы нэгэн жанжин гэж үздэг бөгөөд Төвдчүүд “Барс хөтөлсөн монгол хүн” гэж ярьдаг байна. Ийм учраас энэ дуу нь Хөхнуурт дуулагдаж байсан олон монгол дууны дотроос арай илүү хүчтэй, нөлөөтэй байсан байж болох юм. Тийм учраас энэ дуу нь бас нэмэгдэн зохиогдсон тал бий. Тухайлбал дээр иш татсан эхний хоёр бадгийн дараа “Улаан шандын ус” бадагтай хослуулан “Хөх шандын ус” гэх бас нэгэн бадаг нэмэгдэж зохиогдсон байна. Нэмэгдэж зохиосон гэж хэлж байгаа нь даруй халх хувилбарт энэ бадаг нь өөр байдаг юм. Хөхнуур Сүбэй Монголчуудын ардын дуунд халх ардын дууны нөлөө тусгал байгааг, бас өөр өөр, адил бус дууны жишээнээс мэдэж болох юм. Халх монголд “Бор борын бялзуухай” (Хөхнуурт “Хүүхэн хутагтын дуу” гэдэг) энэ дууны зарим мөр бадаг нь Хөхнуурын “Нар Банчин богд” дуунд орсон байдаг. Хэрвээ зарим хүмүүсийн заншсан ёсоор хүүхэн хутагтыг Хөхнуур буюу Баруун монголд Нар Банчин гэж дуулдаг байсантай уялдуулж үзвэл энэ дуу нь нэн сонин болох юм. Гэтэл Хөхнуур Монголчуудад “Нар Банчин богд” гэж нэрлэн хүмүүс шүтэж байхад, харин Ар халх буюу бусад монгол газарт “Хүүхэн хутагт” гэж шүтэж байгаагаас үзвэл Нар Банчин богд хийгээд хүүхэн хутагт гэдэг нь нэгэн хүн биш гэхэд, нэгэн хувилгаан дүр, нэг бүлэг шашны урсгалын хамаа бүхий харьцаа

⁶Цэрэнбал Гүнрэгмаа (2000) *Дээд Монголын ардын дуу*. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо.,

⁷Бат. Д. (2000) *Алиаа дахь халхчуудын уртын дууны уламжлал*. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо.,

холбоотой, монгол хүний ахуй амьдрал, сэтгэц, сүсэг бишрэлтэй ямар нэгэн холбоотой гэгээн богд болох нь мэдээж юм.

Үүнээс гадна “Нар Банчин богд” гэх дууг, Хөхнуурт Ойрдын Шонуу баатартай холбож дуулсан хувилбар ч байдаг. Энэ тухай өмнө нь нэгэнтээ ярьсан тул энд товч өгүүлье. Харин энэ хоёр дууны уламжлалын адил тал гэвэл Нэг: Богд, хутагт, хувилгаан болгон дүрсэлсэн байна. Нөгөөд: Баатар сайн эр болгож дуулсан байна. Ямар холбоотой байна вэ гэвэл ноён хутагт буюу Нар Банчиныг магтсан талаараа, мөн монголын уламжлалт баатрын шүтлэг буюу бурхан шашны сүсэг бишрэл, итгэл ерөөлийн сэтгэл хүслийн нягт уялдаатайгаар ижил төсөөтэй юм.

Үүнтэй төстэй өөр нэгэн дууны уламжлал жишээг дурдвал, Хөхнуур Сүбэй Монголчуудын дунд “Хол гүйгч хээр халтар морь” гэдэг дуунд:

“Хэт хол гүйгч хээр халтар морь бий

Хэмжээлигүй хайрладаг эжий аав хоёр минь бий

Цагаан цоохор мориныхоо сээр дээр өслөө би

Цал буурал эжийнхээ өвөр дээр өслөө би

Хөх цоохор мориныхоо сээр дээр өслөө би

Хөгийн буурал эжийнхээ өвөр дээр өслөө би

Ганга нуурын гургуул нь гашил талдаа жиргэнэ

Газар усаа санахад тогтон сууж ядна би

Энх нуурын гургуул эргин дээшээ жиргэнэ

Ээж аавыгаа санахад тогтон сууж ядна” гэж гардаг⁸. Мөн энэ дууны нэгдүгээр бадгийг халхын “Хээр халтар морь” дуутай харьцуулж үзэхэд мөр бадгийн агуулга зэрэг нь ондоо боловч ерөнхий хөг аяс, дууны зориулалт, утга санаа зэргээс хурим найрын дуу болох нь тодорхой байна. Халх ардын дуунд “Хээр халтар морь нь хэнийхээ адуунд байх бол, хилин зантай авхай нь хэнийхээ ойр суудаг бэ?” гэдэг бол Хөхнуур Сүбэйн хувилбарт энэ дууны мөр бадгийг “Хөхөө шувуу” гэдэг дуун дахь:

“Хулсийг хумируулдаг хур салхин хоёр бий

Ургийг уяруулдаг эжий аав хоёр бий

Элсийг уяруулдаг үер хур хоёр

Элгийг энхэрүүлдэг эжий аав бий”⁹ гэх бадгийг оруулж дуулсан байдаг. Энэ үзэгдлийг харахад эндэгдэл буюу сольж дуулсан шинжтэй боловч, ингэж солигдож холигдож дуулахын учир нь “Хөхөө шувуу” дуу хийгээд “Хээр халтар морь” гэдэг дуун нь адилхан охин үрээ харьд мордуулахад дуулдаг дуу байдгаас тийм үзэгдэл гарсан бололтой.

Хөхнуур Сүбэй Монголчуудын “Хэт хол гүйгч хээр халтар” дуунд гарах зарим бадаг нь халх ардын дуу болох “Хөвлөг хангайн бараа” гэх дуутай төсөөтэй байна. Жишээлбэл: “Хөвлөг хангай бараа” хэмээх дуунд:

“Ганга нуурын галуу халиуран бууж жиргэнэ

Газар нутгаа санахад тогтон сууж ядна л

Эргин нуурын галуу эргэж бууж жиргэнэ

⁸ - Цэрэнбал Гүнрэгмаа *Дээд Монголын ардын дуу*. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо. 2000

⁹ - Цэрэнбал Гүнрэгмаа *Дээд Монголын ардын дуу*. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо. 2000

Ээж аагаа санахад тогтон сууж ядна л”¹⁰ гэсэн хоёр бадгийг өмнө жишээтэй харьцуулж

үзэж болох юм. Энэ нь Хөхнуур Сүбэй Монголчуудын дуунд халх дууны нөлөө тусгал байсан буюу ганц хоёр дуу төдий биш цөөнгүй халх дууг Хөхнуурын газарт буюу Хөхнуур Монголчуудын дунд дуулж байсны нэгэн гэрч юм.

Өмнө нэгэнт нэр заасан “Шовгор Даржаа” буюу “Даржаа гуай” гэдэг дуу нь хэдийгээр богино дуу боловч түүх уламжлал нь эдүгээ монгол улсад төдийлөн яригдахаа больсон буюу мартагдсан байхад харин, Хөхнуур, Сүбэй Монголчуудын дунд тэр дууг Хөхнуурт дуулж байсан халх хүн, даруй ар Халхын Дарьганга хошууны хүн, мөн түүний ярьсан домог, тухайлбал хуучин Халхын Дарьганга хошуунд Даржаа гэдэг хүн байгаад Да хүрээнд хүрч Тогос гэдэг хэцүү догшин ноёны авгайтай сайн болоод, айл гэр болох гэхэд Тогос ноён түүнийг гянданд хориулжээ. Үүнээс энэ харилцаа дуу гарсан түүхтэй аж.

Нэгдүгээр дуунд Даржаа:

“Шоронгийн үүдэнд шомболзуулаад гардаг

Шовгор Даржаа би ч байна даа хө хө хө

Солихон зантай тулгар хүүхэн чи л

Зангаа яагаад мартчихсан юм бэ хө хө хө

Хадны үүдээр гэдэлзүүлээд гардаг

Гяндан Даржаа би ч байна даа

Гэнэхэн зантай Долгор хүүхэн чи

Зангаа яагаад мартчихсан юм бэ хө хө хө” гэж дуулахад хоёрдугаар дуунд

Долгор:

“Солийн ногоо нь согсолзож байна

Сургийг чинь сонсоод гэнгэрч байна.

Хадын ногоо нь хальж байна

Хань чинь сонсоод хямарч байна

Да хүрээндээ даамалтай шүү Даржаа гуай

Дэмий сэтгэл байна уу даа Даржаа гуай

Ар хүрээндээ ажилтай шүү Даржаа гуай

Амаргүй сэтгэл байна даа Даржаа гуай” гэж хариу дуу барьсан байдаг¹¹. Энэ мэт тухайн цаг үеийн халх монголын шинэ дуу хүртэл ар халхаас алс хол байгаа Хөхнуурын өндөрлөгийн Монголчуудын дунд дэлгэрч, соёолон ургаж, үндэс хатган уламжилж ирсэн ажээ. Иймэрхүү дууны жишээ нь зөвхөн дуучин буюу дууны тус бие төдийгүй харин дууны учир утга санаа зэрэг нь хүмүүст нөлөөлж, Хөхнуур Сүбэй Монголчуудын дотор тэр дууг бусдаас сонсоод, бас дуулж уламжилж байгаад л тэр дууны үнэ цэнэ оршино. Мөн адил нэгэн жишээг дурдвал, Хөхнуурын ардын дуу “Алтай хангайн ард” бас “Ар хангайн халхчууд” гэх дуунд:

“Алтай Хангайн ард аялъя гэлээ

Ар хойшоо гарахад ах дүүгээ санана

Тонгой гүүний унага толботой бор морин

¹⁰ - Цэрэнбал Гүнрэгмаа Дээд Монголын ардын дуу . Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо. 2000

¹¹ - Цэрэнбал Гүнрэгмаа Дээд Монголын ардын дуу . Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо. 2000

Тунараад ирсэн дайсныг бууныхаа сайнаар буцаана.

Эмнэг гүүний унага эрхтэй бор морин

*Эргээд ирсэн дайсныг бууныхаа сайнаар буцаана*¹² гэж дуулж байжээ. Энэ бол Хөхнуур Сүбэй Монголчуудын дунд уламжилж байгаа халх дуу буюу халх хүний түүх намтар, зан суртахуун, баатар зориг зэргийг илтгэсэн бөгөөд мөн ч Хөхнуур Сүбэйн Монголчуудын сэтгэл зүрхэнд адилхан монгол хүний сөс зориг, хүсэл тэмүүлэл, баатар зориг ид хүчээр дайсныг номхотгон буцааж хөөж байгааг магтан дуулсан нь эдүгээ хүртэл уламжилж ирсэн байгаа юм.

Сүүлийн үед илэрч байгаа нэгэн онцгой байдал гэвэл дуучин цөөрснөөс дуу цөөрөх, эсвэл зөвхөн Ойрд дуу буюу Дээд монголчуудын дуу гэх хувийн сэдэв буюу тэр хэмжээн дотор эргэлдсэнээс ихэнх газарт уламжилж байсан, хоорондоо нягт харилцаа холбоотой байсан олон газрын дуу зэрэг нь гээгдэх аюултай болсон байна. Мөн дээр дурдсан халх дууг азаар тэмдэглэж үлдсэн мэргэдийн буянаар ганц хоёр нь үлдэж уламжилж, зарим хэсэг нь зөвхөн үг нь үлдэж, ая аялгуу нь үгүй болж хоцорсон үзэгдэл ч байна.

Судлаач нарын туршлагыг үзэхэд, ардын дууг шинжлэхдээ ердөө ардын аман зохиол хийгээд тухайн ард түмний соёл түүхийн хөрсөн дээр судалж, тухайн дуу хэрхэн түгэн дэлгэрч, хэрхэн уламжлагдан шинэчлэгдэж ирсэн хийгээд, нутаг нутгийн монголчуудын сэтгэл оюунд хэрхэн нөлөөлж ирсэн үнэн төрх байдлыг бодитой илэрүүлэхийг зорьдог байна. Эдгээр нь бидний хойшдын ардын аман зохиол, дуу, зан заншлыг судлахад нандин сургаал болсон юм.

Эцэст нь дүгнэвэл: Хөхнуур Сүбэйн Монголчуудын дуу хийгээд ар халхын дууны харилцаа холбооны асуудлыг авч үзээд **нэгд:** Шашны холбогдол бүхий дууны уламжлах ба харилцан нөлөөлөх нь арай илүү байгааг, **хоёрт:** Төрөл саднаа санагалзах буюу хурим найрын дуу нь нөлөөллийн хувьд илүү уламжлах нөхцөлтэй байдгийг, **гуравт:** Шинэ үзэл санаа ухуулсан буюу баатар эр, ардын шүтээн болсон богд хувилгаадын дуу зэрэг нь адил бус газар нутгийн монголчуудын дунд уламжилж шинэчлэх олон суурьтай байгаа зэргийг дүгнэн тодорхойлж болно.

¹²-Цэрэнбал, Гүнрэгмаа *Дээд Монголын ардын дуу*. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо. 2000

НОМЗҮЙ

1. Бат. (1999) *Цахиурт мэргэн богд хаан*. Алшаа дахь Монголчуудын аман үлгэрийн түүвэр. Улаанбаатар.,
2. Бат. (2004) *Алшаа дахь Халхчуудын уртын дууны уламжлал*. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо.,
3. *Сүбэй Монгол ардын дуу*. (1980) Баруун Хойтын Үндэстний Дээд сургуульд 1977 онд элссэн монгол салбарын оюутны цуглуулсан материал.
4. Халиун. Оюунцэцэг. (2001) *Дээд Монголын газрын нэрийн домог*. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо.,
5. Цэрэнбал. Гүнрэгмаа. (2000) *Дээд Монголын ардын дуу*. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо.,
6. Чойдандар. (2007) *Баруун цастын халх үндэстний судлал*. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо.,
7. Халиун. Оюунцэцэг. (2001) *Дээд Монголын газрын нэрийн домог*. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо.,

SUMMARY

Through this article, we attempted to do some research work on the interrelation of the songs, sung by the Ethnic Mongolians living in Khukhnuur, and Su bei, PRC as well as in Outer Mongolia. Then we have drawn the conclusions as the following:

1. Some related to any religion, have been greatly passed down and more significantly interacted with each other.
2. Some related to the heart to miss the relatives or the feast and celebration, have an opportunity to influence on.
3. Some composed for the propagation, heroes and reincarnations, have been passed to the Mongolians in different places and can be renewed easily.